



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/117

Мандалговь

“Тааны амт” ХХК-тай гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн А/69 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Бог мал угаах ванн шинээр барих ажил”-ын багц-3 (Дундговь, Баянжаргалан, Говь-Угтаал, Цагаандэлгэр сум) гүйцэтгэгчээр шалгарсан “Тааны амт” ХХК-тай 71,251,490 (далан нэгэн сая хоёр зуун тавин нэгэн мянга дөрвөн зуун ер) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Ажлын зураг, төсвийн дагуу “Бог мал угаах ванн шинээр барих ажил”-ын багц-3 (Дундговь, Баянжаргалан, Говь-Угтаал, Цагаандэлгэр сум) чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Тааны амт” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Ю.Отгондэлгэр)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Мал эмнэлгийн дарга (Ш.Мөнхдүүрэн), Баянжаргалан сумын Засаг дарга (Т.Цэвэлмаа), Говь-Угтаал сумын Засаг дарга (Ө.Мөнх-Амгалан), Цагаандэлгэр сумын Засаг дарга (Д.Буджав) ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060490